



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/16


Улаанбаатар хот

Ш.Чанцалнурмаад чөлөө олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тохижилт, Хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Шагдарсүрэн Чанцалнурмаа хүүхдээ эмнэлэгт сахих болсон тул гаргасан хүсэлтийг нь харгалзан дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.19.6 дахь заалтын дагуу 2019 оны 01 дүгээр сарын 23-наас 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийг дуустал ажлын 3 хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. Ш.Чанцалнурмаагийн эзгүйд албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж, ажил үүргийн уялдаа холбоог хангаж ажиллахыг Тохижилт, Хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Г.Ууганбаярт даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

